



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 10 өдөр

Дугаар A/164.

Бат-Өлзий сум

Г Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг  
тооцох ажлын хэсэг байгуулах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам”-ын 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 6 дугаар багийн нутаг Цагаан азаргын Хан баян-уулын хормой гэх газарт 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр гарсан ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

О.Отгонтуяа (Санхүүгийн албаны дарга)

Д.Очирхуяг (сум дундын Ойн ангийн дарга)

Д.Дэмиддагва (Багийн Засаг дарга)

Х.Чулуунбат (Тусгай хамгаалалттай газрын

байгаль хамгаалагч)

М.Мөнхдалай (Байгаль хамгаалагч)

2. Ойн модны шаталтын зэрэглэл, түймрээс учирсан хохирлыг тогтоож, акт үйлдэн холбогдох газарт материалыг хүргүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (Н. Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН